



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан
өвчин, хурц хордлогыг судалж, бүртгэх
комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан “Аж ахуй нэгж байгууллагын үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссын ажиглах заавар”, “Зам тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг судалж бүртгэх, акт гаргаж, дүгнэлт хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Авто замын ашиглалтын хэлтсийн дарга

Нарийн бичиг: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ахлах мэргэжилтэн

Гишүүд: Төлбөр авах үйл ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн

Лабораторийн ахлах инженер

Хүний нөөц, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн

Барилга угсралт хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Хууль, гэрээний мэргэжилтэн

Үйлдвэрчний хорооны дарга

2. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, хурц хордлогыг судалж, бүртгэх комиссын ажлыг зохих хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг комиссын дарга (А.Ханбаяр)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Д.Базарсад)-д даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан тус үйлдвэрийн газрын 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/165 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Х.ПҮРЭВЖАРГАЛ



16244183